

## САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний ТЗЭ байгууллагуудын үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн доорх хүснэгтэд үзүүлж байна /Хүснэгт 19/. 2022 онд Архангай аймгийн Эрдэнэмандал суманд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа эрхэлдэг “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ шинээр тусгай зөвшөөрөл авсан.

**Хүснэгт 1. ТЗЭ байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	өсөлт + бууралт -
1	<b>Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч</b>	<b>тоо</b>				<b>0</b>
	Үүнээс: Хяналт үнэлгээнд хамрагдах	тоо	131	131	129	-2
	Хяналт үнэлгээнд хамрагдсан	тоо	125	127	126	-1
	<b>Хяналт үнэлгээнд хамрагдсан хувь</b>	<b>%</b>	<b>95.4%</b>	<b>96.9%</b>	<b>97.7%</b>	<b>0.7%</b>
2	Олборлосон ус	мян.м3	114,235.9	116,991.5	115,656.1	-1,335
	Олборлосон, дамжуулан түгээсэн усны хэмжээ	мян.м3	37,658.0	40,321.9	41,400.6	1,079
	Борлуулсан усны хэмжээ	мян.м3	133,696.6	140,474.5	138,059.6	-2,415
	Өөрийн хэрэглээний усны хэмжээ	мян.м3	952.1	767.0	1,101.1	334
	Орлого болоогүй усны хэмжээ	мян.м3	17,245.3	16,071.9	17,896.1	1,824
	<b>Усны алдагдал (ОБУ)-н хувь</b>	<b>%</b>	<b>11.4%</b>	<b>10.2%</b>	<b>11.4%</b>	<b>1.2%</b>
3	Татан зайлуулсан бохир усны хэмжээ /давхардсан тоогоор/	мян.м3	94,694.3	102,724.9	102,915.9	191
4	<b>Нийт хэрэглэгчийн тоо</b>	<b>тоо</b>	<b>623,786</b>	<b>614,728</b>	<b>675,241</b>	<b>60,513</b>
	Үүнээс: Аж ахуйн нэгж байгууллага	тоо	33,143	28,265	34,028	5,763
	Айл өрх - орон сууцны	тоо	335,006	363,061	376,972	13,911
	Зөөврийн хэрэглэгч	тоо	255,637	223,402	264,241	40,839
5	<b>Хэрэглэгчийн тоолууржилт, улсын дундаж</b>	<b>%</b>	<b>89.0%</b>	<b>90.7%</b>	<b>91.9%</b>	<b>1.2%</b>
	Албан байгууллага	%	99.5%	99.8%	99.7%	-0.1%
	Орон сууцны айл өрх	%	88.0%	89.9%	91.2%	1.3%
6	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	<b>тоо</b>	<b>10,463</b>	<b>11,423</b>	<b>12,088</b>	<b>665</b>
	Улсын дундаж цалин	төг/сар	1,120,300	1,279,400	1,750,200	470,800
	Салбарын дундаж цалин	төг/сар	1,170,975	1,193,673	1,435,203	241,530
7	УХАТ-ын үйл ажиллагааны нийт орлого	сая.төг	195,259.8	225,168.9	295,451.6	70,283
	УХАТ-ын үйл ажиллагааны нийт зардал	сая.төг	234,071.4	259,007.2	318,430.0	59,423
	УХАТ-ын үйл ажиллагааны нийт ашиг, алдагдал	сая.төг	-38,811.6	-33,838.3	-22,978.4	10,860
8	<b>Орлогын 1 төгрөгт ногдох зардал-(Зонтн)</b>	<b>төгрөг</b>	<b>1.20</b>	<b>1.15</b>	<b>1.08</b>	<b>-0.07</b>
9	<b>УХАТ-н үйл ажиллагааны Ашгийн норм</b>	<b>-</b>	<b>-0.20</b>	<b>-0.15</b>	<b>-0.08</b>	<b>0.07</b>
10	<b>1 м<sup>3</sup> усанд ногдох зардал: Цэвэр усанд</b>	<b>төг/м3</b>	<b>1,193.2</b>	<b>1,246.9</b>	<b>1,570.2</b>	<b>323</b>
	<b>Бохир усанд</b>	<b>төг/м3</b>	<b>787.2</b>	<b>816.2</b>	<b>972.7</b>	<b>157</b>
11	<b>Санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлт: Нийт хөрөнгө, эх үүсвэр</b>	сая.төг	<b>1,509,719.5</b>	<b>1,693,084.3</b>	<b>1,767,040.8</b>	<b>73,956</b>
	Эргэлтийн хөрөнгө	сая.төг	286,004.3	298,787.2	448,710.5	149,923
	Үндсэн хөрөнгө	сая.төг	1,223,715.1	1,394,297.1	1,318,330.3	-75,967
	Дансны авлага	сая.төг	86,450.3	128,244.3	122,424.4	-5,820
	Өр төлбөр	сая.төг	497,985.1	323,364.5	389,616.7	66,252
	Үүнээс: Богино хугацаат төлбөр	сая.төг	158,232.5	151,654.6	199,550.3	47,896
	Урт хугацаат төлбөр	сая.төг	339,752.6	171,710.0	190,066.4	18,356
12	<b>Санхүүгийн тайлангийн шинжилгээ: Эргэлтийн харьцаа</b>	2-с дээш	0.59	0.97	1.15	0.18
	Төлбөр гүйцэтгэх чадварын харьцаа	1-с дээш	0.89	1.20	1.22	0.02
	Балансын ашгийн норм	>0	-0.08	0.15	-0.07	-0.22


Дээрх хүснэгтийн дүнгээс үзэхэд салбарын хэмжээнд усны олборлолт, борлуулалт буурсан бөгөөд орлого болоогүй усны эзлэх хувь улсын дунджаар 11.4 хувь болж өмнөх оноос 1.2 пунктээр өссөн байна.

Тайлант оны дүнгээр нийт хэрэглэгчдийн тоо нь 60,513-ээр өссөн бөгөөд үүний дотор зөөврийн болон ус түгээх байрны хэрэглэгч 40.8 мянга, айл өрхийн хэрэглэгч 13.9 мянга, ҮААНБ-ын тоо 5.8 мянгаар тус тус өссөн байна. Ийнхүү шинээр хэрэглэгч нэмэгдсэн нь нийслэл, аймгийн төвүүдэд орон сууц шинээр баригдан ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөсөн зэргээс голчлон шалтгаалжээ.

#### **4.1 Тарифын зохицуулалт:**

2022 онд: Архангай аймгийн Эрдэнэмандал сум, Говьсүмбэр аймгийн Шивээговь сум, Дархан-Уул аймаг, Дорнод аймаг, Завхан аймгийн Улиастай сум, Сэлэнгэ аймгийн Мандал сумын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифт зохицуулалт хийсэн. Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд цэвэр, бохир усны үйлчилгээний тарифт цаг алдалгүй зохицуулалт хийж, зардалд хяналт тавин ажиллаж байгаагийн үр дүнд салбарын орлого нэмэгдэж байгаа боловч зарим аймгийн ТЗЭ-д саналаа ирүүлдэггүй, орон нутгийн удирдлага зөвшөөрөхгүй байдаг, алдагдлаа бууруулах талаар санаачлага муутай ажиллаж байгаа зэргээс хамааран харьцааны үзүүлэлтүүд доогуур хэвээр байна.

**График 1. Дундаж тариф төг/л**




#### **4.2 Усны баланс**

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй 129 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 50 нь ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж

хариуцан ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн дүнгээр нийт 157.1 сая.м<sup>3</sup> ус олборлон, боловсруулж, дамжуулан хэрэглэгчдэд нийлүүлжээ.

**График 2. Усны баланс мян.м<sup>3</sup>**



Мөн онд тусгай зөвшөөрөл эзэмшигчид давхардсан тоогоор 138.0 сая м<sup>3</sup> ус борлуулж, орлого болоогүй усны хэмжээ нь 17.9 сая м<sup>3</sup> буюу 11.4% байна. Одоогийн байдлаар хэрэглэгчдийг бүрэн тоолууржуулаагүй тул усны биет алдагдлыг тодорхойлоход хүндрэлтэй, зөвхөн орлого болоогүй усны хэмжээг тооцож гаргах боломжтой байдаг.

Тайлант онд “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ нийт 57.4 сая м<sup>3</sup>, Өмнөговь аймгийн “Энержи интернэшнл” ХХК 14.4 сая м<sup>3</sup>, Орхон аймгийн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 26.2 сая м<sup>3</sup> ус тус тус олборлосон нь салбарын хэмжээнд олборлосон нийт усны 84.8%-ийг эзэлж байна.

Орлого болоогүй ус хувийн хэвшлийн компаниудын дунджаар хамгийн бага буюу 5.2% байгаа бол УСУГ-ынх 15.2%, ОСНААУГ-ынх 8.3% байжээ. Аймаг орон нутгийн дүнгээр 12.4% байгаа боловч үүнд Баянхонгор аймгийн “Чандмань Баянхонгор” ХК, Дархан-Уул аймгийн “Дулаан шарын гол” ТӨХК, Булган аймгийн “Булган мээж” ХХК-ийн орлого болоогүй ус хамгийн их буюу 50.2-53.6% байгаа бол Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ, Сүхбаатар аймгийн “Дөрвөлж” ОНӨААТҮГ, Хэнтий аймгийн “Хэнтий ус” ХХК-ийн орлого болоогүй ус нь 40% байна.


**Хүснэгт 2. Аймаг орон нутгийн ТЗЭ-дийн усны баланс**

№	Харьяалал	Олборлосон/ худалдан авсан усны хэмжээ мян.м <sup>3</sup>	Борлуулсан усны хэмжээ мян.м <sup>3</sup>	Өөрийн хэрэглээний усны хэмжээ мян.м <sup>3</sup>	Орлого болоогүй усны хэмжээ мян.м <sup>3</sup>	Усны алдагдлын хувь
1	Архангай	363.09	259.66		103.43	28.5%
2	Баян-Өлгий	680.00	363.16	63.00	253.84	37.3%
3	Баянхонгор	1,054.07	459.23	37.56	557.28	52.9%
4	Булган	231.43	114.08	1.22	116.13	50.2%
5	Говь-Алтай	579.59	291.69	53.22	234.68	40.5%
6	Говьсүмбэр	209.00	120.31	10.63	78.06	37.3%
7	Дархан-Уул	2,559.90	1,786.39		773.51	30.2%


8	Дорноговь	510.00	340.07	23.90	146.03	28.6%
9	Дорнод	1,556.33	842.15	201.68	512.50	32.9%
10	Дундговь	249.30	191.88	36.00	21.42	8.6%
11	Завхан	365.00	295.47		69.54	19.1%
12	Орхон	30,140.16	28,559.47		1,580.69	5.2%
13	Өвөрхангай	386.94	322.45		64.49	16.7%
14	Өмнөговь	545.00	417.96	1.47	125.57	23.0%
15	Сүхбаатар	395.28	236.12	0.07	159.09	40.2%
16	Сэлэнгэ	920.39	545.86	8.54	365.99	39.8%
17	Төв	415.80	331.02	27.48	57.30	13.8%
18	Увс	551.90	324.78	25.00	202.12	36.6%
19	Ховд	1156	657.09	265.20	233.71	20.2%
20	Хөвсгөл	407.3	338.97	1.00	67.33	16.5%
21	Хэнтий	456.59	271.62	1.00	183.97	40.3%
Орлого болоогүй усны дундаж						29.5%

Дээрх хүснэгтээс харахад дунджаар орлого болоогүй усны хэмжээ 39.5% байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд цаашид бүх ТЗЭ нар усны алдагдлыг бууруулах, тоолууржилтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

**График 3. Орлого болоогүй усны хувь /Аймаг, орон нутгийн төвийн ТЗЭ-чид/**



#### **4.3. Хэрэглэгчийн судалгаа, тоолууржилт:**



**Хэрэглэгчийн судалгаа:** 2022 оны жилийн эцсийн дүнгээр ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нийт 675.2 мянган хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байгаагаас 34.0 мянган хэрэглэгч буюу 9 хувь нь үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага, 377.0 мянга буюу 53.6 хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон айл өрх, зөөврийн болон УТБ-аас цэвэр усаар хангагдаж буй хэрэглэгч 264.1 мянган хэрэглэгч буюу 38 хувийг тус тус эзэлж байна. Нийт хэрэглэгчийн тоог өмнөх онтой харьцуулахад 60.5 мянгаар нэмэгдсэн бөгөөд орон сууцны хэрэглэгчийн тоо 4%-иар, YAANB болон УТБ-ны хэрэглэгчийн тоо 20%-иар тус тус өссөн байна. /Хүснэгт 3/

**Хүснэгт 3. Хэрэглэгчийн судалгаа**

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	өсөлт + бууралт -
<b>Нийт хэрэглэгчийн тоо</b>	<b>тоо</b>	<b>623,786</b>	<b>614,728</b>	<b>675,241</b>	<b>60,513</b>
YAANB	тоо	33,143	28,265	34,028	5,763
Айл өрх - орон сууцны	тоо	335,006	363,061	376,972	13,911
УТБ, Зөөврийн хэрэглэгч	тоо	255,637	223,402	264,241	40,839

Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугамд холбогдсон өрхийн тоо 377 мянга байгаа бөгөөд үүнээс тоолуургүй хэрэглэгчийн тоо 33.3 мянга буюу тоолууржилт 91.2% байна. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тоо нийт 34 мянга байгаагаас тоолуургүй YAANB 106 буюу тоолууржилт 99.7% байна.


**Хүснэгт 4. Тоолууржилтын судалгаа**

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	өсөлт + бууралт -
<b>Хэрэглэгчийн тоолууржилт, улсын дундаж</b>	<b>%</b>	<b>89.0%</b>	<b>90.7%</b>	<b>91.9%</b>	<b>1.2%</b>
<b>YAANB:</b>	Тоо	33,143	28,265	34,028	5,763
Тоолууртай	Тоо	32,964	28,200	33,922	5,722
Тоолуургүй	Тоо	179	65	106	41
Тоолууржилт	%	99.5%	99.8%	99.7%	-0.1%

<b>Айл өрх:</b>	Тоо	335,006	363,061	376,972	13,911
Тоолууртай	Тоо	294,831	326,567	343,637	17,070
Тоолуургүй	Тоо	40,175	36,494	33,335	-3,159
Тоолууржилт	%	<b>88.0%</b>	<b>89.9%</b>	<b>91.2%</b>	<b>1.3%</b>

Тайлант онд төвлөрсөн шугамд холбогдсон хэрэглэгчийн тоолууржилтын түвшин улсын дунджаар 91.9% байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 1.2 пунктээр өсчээ. /Хүснэгт 4/

**График 4. Тоолууржилт /байршлаар/**



Аймаг, орон нутгийн YAANB-ын тоолууржилт 98.9% байгаа бол айл өрхийн тоолууржилтын хувьд ОСНААУГ ОНӨААТҮГ-ынх хамгийн бага буюу 83.5% байна. Харин сүүлийн жилүүдэд шинээр ашиглалтад орж байгаа орон сууцны барилга бүрэн тоолууржсан байдаг тул хувийн хэвшлийн компаниудын тоолууржилтын түвшин харьцангуй өндөр буюу 99.6% байна. /График 3/

**Хүснэгт 5. Аймагийн төвийн ТЗЭ-дийн тоолууржилт**

Харьяалал	YAANB тоо	Тоолууржилт %	Айл өрхийн тоо	Тоолууржилт %
"Ар-Ус ундарга" ХХК	216	86.6%	1,794	81.2%
"Суат" ХХК	297	100.0%	2,208	48.5%
"Чандмань Баянхонгор" ХК	349	100.0%	3,212	89.7%
"Булган мээж" ХХК	153	100.0%	4,308	100 %
"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ	200	100.0%	5,453	58.2%

"Ус-Ду" ОНӨААТҮГ	50	100.0%	1,120	100 %
"Дархан ус суваг" ХК	1,350	100.0%	62,442	99.3%
"Чандмань Илч" ХХК	573	100.0%	4,717	100 %
"Дорнод НАА" ОНӨААТҮГ	744	95.6%	15,077	96.0%
"Дундговь-Ус" ХХК	172	100.0%	9,549	100 %
"Амь-Ус" ХХК	237	100.0%	7,205	30.2%
"Эрдэнэт ус ДТС" ОНӨХК	2,053	97.4%	13,814	97.2%
"Онги ус суваг" ОНӨААТҮГ	260	100.0%	12,562	100 %
"Гүний ус" ХХК	407	100.0%	9,683	89.9%
"Дөрвөлж" ОНӨААТҮГ	226	100.0%	7,512	98 %
"Сэлэнгэ цэнгэг ус" ОНӨААТҮГ	406	100.0%	5,111	27.4%
"Төв чандмань ДЭХГ" ОНӨҮГ	196	100.0%	6,595	65.1%
"Чандмань Увс" ХХК	235	100.0%	5,413	73.2%
"Шим-Ус" ОНӨААТҮГ	206	100.0%	8,999	61.4%
"Хөвсгөл ус суваг" ХХК	233	100.0%	11,869	88.4%
"Хэнтий ус" ХХК	218	96.8%	6,097	93.4%
"УСУГ" ОНӨААТҮГ	4,787	100.0%	2,158	86.9%
"ОСНААУГ" ОНӨААТҮГ	10,829	100.0%	118,280	83.5%

Айл өрхийн хувьд "Булган мээж" ХХК, "Ус-Ду" ОНӨААТҮГ, "Чандмань илч" ХХК, "Дундговь ус" ХХК, "Онги ус суваг" ОНӨААТҮГ 100% тоолууржсан бол "Сэлэнгэ цэнгэг ус" ОНӨААТҮГ, "Төв чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ, "Амь ус" ХХК, "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ, "СУАТ" ХХК, "Шим ус" ОНӨААТҮГ-ын тоолууржилт доогуур үзүүлэлттэй байгаа тул тоолууржилтаа нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

"Ар ус ундарга" ХХК, "Дорнод НАА" ОНӨААТҮГ, "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК, "Хэнтий ус" ХХК-ийн хариуцдаг ҮААНБ-ын тоолууржилт 86.6-97.4% байгаа бол бусад байгууллагын ҮААНБ 100% тоолууржсан байна. /Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоолууржилтыг хавсралт ... үзүүлэв/

### Ухаалаг тоолуур

#### 4.3. Тасалдал, гомдол:

#### Хүснэгт 6. Усны тасалдлын судалгаа

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Төлөвлөгөөт /мин/	Шугам т/г-ийн гэмтэл /мин/	Бусад /мин/	Нийт /мин/
УСУГ ОНӨААТҮГ	19,440	1,105	570	21,115
УБ хот: Бусад ОНӨААТҮГ-ууд	5760	1,260		7,020



УБ хот: Хувийн хэвшлийн компаниуд	40,069	52,089	10,206	102,364
Аймаг орон нутгийн байгууллагууд	135,858	208,986	137,569	482,413
<b>Нийт тасалдал</b>	<b>181,687</b>	<b>262,335</b>	<b>147,775</b>	<b>591,797</b>

“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын хувьд 2022 онд нийт 21,115 минут цэвэр ус хангамж тасалдсан бөгөөд хоногт шилжүүлж үзэхэд 15 хоног бөгөөд санхүүгийн хувьд 4 тэрбум төгрөгийн орлого олох боломж нь алдагдсан байна.

Улаанбаатар хотын хувийн хэвшлийн конторуудын хувьд цэвэр ус хангамжийн тасалдлын нийт хугацаа нь 102,364 минут буюу 71 хоног байгаа нь санхүүгийн хувьд 730 сая төгрөгийн орлогын боломж нь алдагдсан байна.

Аймаг, орон нутгийн ТЗЭ-дийн хувьд нийт 482,413 минут цэвэр ус хангамж тасалдсан бөгөөд үүний 190,000 минут нь Өмнөговь аймгийн “Гүний ус” ХХК байгаа бол 105,900 нь “Дархан ус суваг” ХК байна. Үүнийг хоногоор тооцоход 335 хоног буюу орлогын алдагдсан боломж нь 2.5 тэрбум төгрөг байна.

Иймд шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүрт хийж цэвэр ус хангамжийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

#### **Хүснэгт 7. Хэрэглэгчийн дуудлага, санал гомдлын судалгаа**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ангилал	Усны тасалдал		Усны чанар		Төлбөр тооцоо		Засвар үйлчилгээ		Үйлчилгээ /харилцааны соёл/		Хэрэглэгчийн нийт дуудлага, санал	
	ирсэн	Шийдвэрлэсэн	ирсэн	Шийдвэрлэсэн	ирсэн	Шийдвэрлэсэн	ирсэн	Шийдвэрлэсэн	ирсэн	Шийдвэрлэсэн	ирсэн	Шийдвэрлэсэн
УСУГ ОНӨААТҮГ	160	160	3	3	237	237	22,809	22,809	0	0	23,209	23,209
УБ хот ОНӨААТҮГ-ууд	1	1	7	7	2	2	1,960	1,960	0	0	1,970	1,970
УБ хот Хувийн хэвшлийн ААН-д	7,399	7,384	8,724	8,726	9,849	9,831	113,278	113,240	1,995	1,985	141,245	141,166
Орон нутгийн байгууллага	1,956	1,941	7,019	7,012	838	828	57,473	55,874	132	129	67,418	65,784
<b>НИЙТ ДҮН</b>	<b>9,516</b>	<b>9,486</b>	<b>15,753</b>	<b>15,748</b>	<b>10,926</b>	<b>10,898</b>	<b>195,520</b>	<b>193,883</b>	<b>2,127</b>	<b>2,114</b>	<b>233,842</b>	<b>232,129</b>


Хэрэглэгчийн санал, гомдлын хувьд 233,842 дуудлага ирсэн бөгөөд 232,129-ийг нь шийдвэрлэсэн байна. Ирүүлсэн нийт дуудлагын 4% нь усны тасалдалтай холбоотой, 7% нь усны чанартай, 5% нь төлбөр тооцоотой холбоотой, 84% нь засвар үйлчилгээтэй холбоотой, 1% нь үйлчилгээтэй холбоотой дуудлага эзэлж байна. Харин нийт орлогын 1% буюу 3.2 тэрбум төгрөгийг засвар үйлчилгээний орлого эзэлдэг.

#### **4.4. Хүний нөөц, цалин:**




Тайлант онд ус хангамж, ариутгах татруугын ашиглалт, үйлчилгээний ТЗЭ-дийн хувьд нийт 12,088 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд үүнээс аймаг, орон нутагт 4,737, Улаанбаатар хоты хувийн хэвшлийн конторын ажиллагсдын тоо 3,053, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-т 1883 байгаа бол, “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ нь 1938 ажиллагсадтай ажиллаж байна.

**График 5. Ажиллагсдын судалгаа**




Нийт ажиллагсдын 4%-ийг буюу 440 нь удирдлага, 2517 буюу 21%-ийг инженер, техникийн ажилчид, үлдсэн 75%-ийг буюу 9131 нь мэрэгжилтэй ажилчид байна. Ажиллагсдын хүйсийн харьцааны хувьд 35%-ийг эмэгтэй, 65%-ийг эрэгтэй ажиллагсад эзэлж байна.

**График 6. Цалингийн судалгаа**



Нийт ТЗЭ-дийн дундаж цалингийн хэмжээ жил бүр 2-28%-иар өсч 2022 онд 1,435.2 мянган төгрөг болсон хэдий ч улсын дундаж /1,750.2 мян төг/-аас 18%-иар доогуур байна.

**График 7. 2022 оны цалингийн судалгаа**




Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 25% нь буюу 31 байгууллагын дундаж цалин улсын дундаж цалингийн 50%-д хүрэхгүй байгаа нь цаашид тус байгууллагууд мэргэжилтэй боловсон хүчний цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг дээшлүүлэх шаардлага үүсээд байгааг харуулж байна. /Хавсралт ...-ээр нийт ТЗЭ-дийн дундаж цалинг үзүүлэв./

УХАТ-ын салбарын хувьд боловсон хүчний асуудалд онцгой анхаарал хандуулж, цалин хөлсийг нэмэгдүүлэн, нийгмийн хангамжийг дээшлүүлэх нь чадварлаг мэргэжилтнүүдийг татах, салбарыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Нэг ажилтанд ногдох сарын орлого буюу хөдөлмөрийн бүтээмжийг тооцож үзэхэд “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийх хамгийн өндөр буюу 6.2 сая төгрөг байгаа бол “Дундговь-Ус” ХХК-ийнх хамгийн бага буюу 1.5 сая төгрөг байна. Үүнд үйл ажиллагааны ангилал буюу хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа, үйлчилгээний цар хүрээ, хүний нөөцийн зөв зохион байгуулалт зэрэг нөлөөлж байна.

**График 8. Хөдөлмөрийн бүтээмжийн судалгаа**




#### **4.4. Үйл ажиллагааны орлого:**

Тайлант онд ус хангамж, ариутгах татуургын ТЗЭ-д нийт дүнгээр 744.8 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд үүнээс 40%-ийг УХАТ-ын үйл ажиллагаа, 27%-ийг дулаан хангамжийн үйл ажиллагаа, 33%-ийг бусад үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Ус хангамж, ариутгах татуургын хэмжээнд нийт 296.2 тэрбум төгрөгийн орлоготой ажилласны 34%-ийг буюу 101 тэрбум төгрөгийн орлогыг "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ, 35%-ийг буюу 103.3 тэрбум төгрөгийг аймаг, орон нутгийн ТЗЭ-д, 16%-ийг буюу 47.5 тэрбум төгрөгийг "Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ, 14%-ийг 41.2 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын хувийн хэвшлийн конторуудын орлого тус тус эзэлж байна.

**График 9. УХАТ-ын орлого, зардлын үзүүлэлт**




Тарифын зохицуулалтыг 2014 оноос хойш 149 удаа хийсэн бөгөөд үүний үр дүнд ТЗЭ-дийн ус хангамж ариутгах татуургын орлого 2012 онтой харьцуулахад 3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч инфляц, үнийн өсөлт, цалингийн доод хэмжээ нэмэгдэх зэргээс шалтгаалан зардал ч мөн адил 3.2 дахин өссөн байна.

Тайлант оны УХАТ-ын орлогыг өмнөх онтой харьцуулахад 32%-иар өссөн нь 2022 оны 1-р сарын 1-нээс эхлэн аймаг, орон нутгийн 21 ТЗЭ болон Улаанбаатар хотын тарифт өөрчлөлт орсон нь нөлөөлсөн.

Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны орлогын 55%-ийг цэвэр усны орлого, 36%-ийг бохир усны орлого, 6%-ийг суурь хураамжийн орлого, үлдсэн 3%-ийг үйл ажиллагааны бусад орлого эзэлж байна.

Орлогыг хэрэглэгчийн ангилалаар хуваахад 47%-ийг ЯААНБ-ын хэрэглэгчид, 32%-ийг орон сууцны айл өрхийн хэрэглэгч, 17%-ийг бөөний борлуулалт, 2%-ийг ус түгээх байрны орлого бүрдүүлж байна.

**График 10. УХАТ-ын орлогын бүтэц**



“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын орлого өмнөх онтой харьцуулахад 45%-иар буюу 31.2 тэрбум төгрөгөөр, Улаанбаатар хотын бусад орон нутгийн өмчит ТЗЭ болох ОСНААУГ, ХИХУГ, “Чандмань налайх” ОНӨААТҮГ-ын орлогын хувьд


36%-иар буюу 13.4 тэрбум төгрөгөөр, хувийн хэвшлийн компаниудын орлого 31.5% буюу 71 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бөгөөд үүнд хэрэглэгчдийн хэрэглээ нэмэгдсэн болон 2021 онд хийгдсэн тарифын зохицуулалт нөлөөлжээ.

Аймаг орон нутгийн ТЗЭ-дийн орлого өмнөх онтой харьцуулахад 18.7 тэрбум төгрөгөөр буюу 25.5%-иар нэмэгдсэн байна. Үүнд 2021 онд тарифын зохицуулалт хийлгэсэн аймгууд болох “Ундрага-Алтай” ОНӨААТҮГ, “Дархан ус суваг”, “Эрдэнэт ус ДТС”, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Онги ус суваг” зэрэг байгууллагуудын орлогын өсөлт дийлэнх хувийг эзэлж байна.

#### **4.4. Үйл ажиллагааны зардал:**


2022 онд ТЗЭ байгууллагууд үйл ажиллагаандаа 790 тэрбум төгрөгийн зардал гарган ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 26.2%-иар буюу 134.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зардал 318.4 тэрбум буюу 40%-ийг, дулаан хангамжийн үйл ажиллагааны зардал 32%-ийг, бусад үйл ажиллагааны зардал 28%-ийг тус тус эзэлж байна. Харин зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр нь ангилж үзвэл нийт зардлын 46%-ийг аймаг, орон нутгийн ТЗЭ, 23%-ийг Улаанбаатар хотын хувийн хэвшлийн компаниуд, 18%-ийг Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-ууд, 13%-ийг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын зардал эзэлж байна. /График 6./

**График 11. Зардлын бүтэц**



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний хүрээнд 318.4 тэрбум төгрөгийн зардал гарган ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 22.9%-иар буюу 59.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

**График 12. УХАТ-ын зардлын бүтэц**



Аймаг, орон нутгийн байгууллагуудын УХАТ-ын нийт зардал өмнөх онтой харьцуулахад 17.8%-иар буюу 18.7 тэрбум төгрөгөөр өсч 123.6 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан байна. Үүнээс 32%-ийг буюу 39.5 тэрбум төгрөгийг цалингийн зардал, 25%-ийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 27.2 тэрбум төгрөгийг ашиглалтын зардалд зарцуулжээ.

“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын зардал өмнөх оноос 14 тэрбум төгрөгөөр буюу 16.6%-иар өсч 98.3 тэрбум төгрөг болсон бөгөөд нийт зардлын 44%-ийг цалингийн зардал, 30%-ийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 16%-ийг ашиглалтын зардал, 10%-ийг буюу 9.8 тэрбум төгрөгийг засвар үйлчилгээ, контор хангамж, хөдөлмөр хамгаалал зэрэг зардал эзэлсэн байна.

Улаанбаатар хотын бусад ТЗЭ-дийн хувьд 2022 онд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнд нийт 96.5 тэрбум төгрөгийн зардал гарган ажилласан нь өмнөх оноос 38.2%-иар буюу 26.7 тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнд бөөний тарифын өсөлт нөлөөлсөн бөгөөд нийт зардлын 48%-ийг ус худалдан авах зардал эзэлж байгаа бол цалингийн зардал 29%-ийг, үндсэн хөрөнгийн элэгдэл, ашиглалт, засвар үйлчилгээ гэх мэтчилэн бусад зардалд үлдсэн 23%-ийг буюу 22.2 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Салбарын хэмжээнд нийт зардлын 21%-ийг буюу 67.2 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал эзэлж байна. Элэгдлийн зардлын хэмжээгээр байгууллагын ашиг буурах хэдий ч нөгөө талаас хөрөнгийг нөхөх, сайжруулах мөнгөн санг байгуулах боломжийг бий болгодог. Гэтэл ус хангамж, ариутгах татуургын ТЗЭ-дийн хувьд жил бүр алдагдалтай ажиллаж байгаагаас шалтгаалан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүнгээр бодит мөнгөн сан үүсгэлгүй, дотоод санхүүжилтийн эх үүсвэр болгож үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагаандаа зарцуулж байна. ХСУХАТАҮЗЗ-ийн 2018 оны 40-р тогтоолоор “Ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээ”-г тогтоосон байдаг. Иймд дээрх тогтоолыг мөрдөж, тогтоолд заасны дагуу үйлчилгээний тарифт тусгагдсан элэгдлийн зардлыг хуримтлал байдлаар төвлөрүүлэх шаардлагатай байна.

Усны үйлчилгээний тариф өөрийн өртгөөс нь доогуур тогтоогдож байгаагаас тоног төхөөрөмж, шугам сүлжээний засвар үйлчилгээ шаардлагын түвшинд хийгдэхгүй, ажиллагсдын цалин доогуур, нийгмийн зардалд зарцуулах хөрөнгө

хангалтгүй байх, үйлчилгээний чанар муудах нөхцөлийг үүсгэдэг. Иймд Зохицуулах зөвлөлөөс цаашид тарифт цаг алдалгүй зохицуулалт хийх, шат дараатайгаар өртгөө нөхөх түвшинг дээшлүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Гэвч аймаг орон нутгийн байгууллагууд тарифын саналаа ирүүлэхгүй хугацаа алдах, орон нутгийн удирдлага дэмждэггүй зэргээс үүдэн алдагдал нэмэгдэж, засвар үйлчилгээ, шинэчлэл хийх хөрөнгө хүрэлцэхгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

#### **4.5. Ашиг, алдагдал:**

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нийт үйл ажиллагаанаасаа 2022 онд 45.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээн ажилласан нь өмнөх оноос 15 пунктээр буурсан үзүүлэлт юм. Нийт алдагдлын 22.2 тэрбум төгрөгийг ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнээс, дулаан хангамжийн үйлчилгээнээс 48.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн бол бусад үйл ажиллагаанаас 25.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнээс хүлээсэн алдагдлыг өмнөх онтой харьцуулахад 34.4%-иар буурсан бөгөөд нийт алдагдлын 89%-ийг аймаг орон нутгийн байгууллагууд эзэлж байна.

#### ***Хүснэгт 8. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний ашиг, алдагдал***

<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигчид</b>	<b>2020 он /сая төг/</b>	<b>2021 он /сая төг/</b>	<b>2022 он /сая төг/</b>	<b>Өөрчлөлт хувь %</b>
УСУГ ОНӨААТҮГ	-20,969.6	-14,499.5	2,689.6	-118.5%
УБ хот: Бусад ОНӨААТҮГ-ууд /ОСНААУГ, ХИХУГ, Чандмань налайх/	-2,656.6	-630.3	-657.2	4.3%
УБ хот: Хувийн хэвшлийн компаниуд	-2,780.8	-3,524.6	-4,389.0	24.5%
Аймаг орон нутгийн байгууллагууд	-12,404.6	-15,183.8	-19,834.8	30.6%
<b>Нийт алдагдал</b>	<b>-38,811.6</b>	<b>-33,838.3</b>	<b>-22,191.4</b>	<b>-34.4%</b>

“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын хувьд 2021 онд 14.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 2022 онд 2.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь тарифын зохицуулалт хийсний үр дүн юм.

Аймаг, орон нутгийн ТЗЭ-дийн хувьд алдагдал нь 4.7 тэрбум төгрөгөөр буюу 24.5%-иар өссөн нь бараа материал, сэлбэг хэрэгслийн үнэ тасралтгүй өсч байгаатай холбоотой юм. Цаашид ТЗЭ-дийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, үндсэн хөрөнгийн элэгдлийг нормын дагуу жигд байгуулах шаардлагатай байна. Салбарын зардалд хяналт тавьж, тарифын зохицуулалтыг оновчтой хийснээр ТЗЭ байгууллагууд хэвийн ажиллах боломжтой болох юм.


Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийнхний 2022 оны алдагдал нь 24.5%-иар нэмэгдэж 4.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хэрэглэгчийн тоо цөөн, үйлчилгээний хамрах хүрээ бага, УСУГ-тай тооцоо хийх цэвэр, бохир усны бөөний тарифын зохицуулалтыг хийлгэлгүй хугацаа алдсан зэрэг нь тус компаниуд алдагдалтай ажиллах үндсэн шалтгаан болжээ.



#### 4.6. Хөрөнгө:

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагуудын нийт хөрөнгө 1.8 их наяд төгрөг байгаа буюу өмнөх оноос 3%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгийн 75%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байгаа бөгөөд үлдсэн 448.7 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн 27%-ийг мөнгөн хөрөнгө, 27%-ийг дансны авлага, 21%-ийг бараа материал, 24%-ийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлжээ.

**График 13. Санхүүгийн хөрөнгийн үзүүээлт /тэрбум төгрөгөөр/**




**Хүснэгт 9. Хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Мөнгөн хөрөнгө	Дансны авлага	Бараа материал	Бусад	Эргэлтийн бус хөрөнгө	Нийт хөрөнгө
УСУГ ОНӨААТҮГ	44.7	13.0	9.2	1.6	424.9	493.4
Аймаг орон нутаг	43.0	65.4	53.4	67.2	556.3	785.3
УБ хот: Бусад ОНӨААТҮГ	5.8	16.9	3.0	1.6	181.2	208.6
УБ хот: Хувийн хэвшил	27.0	27.1	30.3	39.4	155.9	279.7
<b>Нийт ер төлбөр</b>	<b>120.5</b>	<b>122.4</b>	<b>96.0</b>	<b>109.9</b>	<b>1,318.3</b>	<b>1,767.04</b>

УСУГ ОНӨААТҮГ-ын нийт хөрөнгө 493.4 тэрбум төгрөгийн 86%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байгаа бөгөөд үлдсэн 68.5 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Мөнгөн хөрөнгө нийт эргэлтийн хөрөнгийн 65%-ийг эзэлж байгаа нь эргэлтийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайн байгааг харуулж байна.

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн дансны авлага нь нийт 122.4 тэрбум төгрөг бөгөөд энэ нь өмнөх оноос 4%-иар буурсан хэдий ч нийт эргэлтийн хөрөнгийн 27%-ийг эзэлж байна.

**График 14. Дансны авлагын судалгаа /сая төгрөгөөр/**



“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын авлагын хэмжээ нь 2022 онд өмнөх оноос 62%-иар буурч 13 тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь салбарын нийт авлагын 11%-ийг эзэлж байна.

Аймаг, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн авлага салбарын нийт авлагын 53%-ийг буюу 65.4 тэрбум байгаа нь өмнөх оноос 35%-иар нэмэгдсэн үзүүлэлт юм. “Булган мээж” ХХК, “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК, “Энержи интернэшнл” ХХК, “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ, “Гавшгай ус” ОНӨААТҮГ, “Спирт бал бурам”, “Нью Улаанбаатар Интернэшнл Эйрпорт” ХХК-ийн авлага орон нутгийн нийт байгууллагын 88%-ийг эзэлсэн байна.

Улаанбаатар хотын бусад ОНӨААТҮГ-ын авлагын дийлэнх хувийг буюу 95%-ийг “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын авлага эзэлж байгаа бөгөөд хувийн хэвшлийн компаниудын авлага 18%-иар буурч 27 тэрбум төгрөг болсон байна.

Салбарын нийт үндсэн хөрөнгө нь тайлант онд 1,126.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний зардалд 46.3 тэрбум төгрөгийн хөрөнгийн элэгдэл тусгагдсан байна.

**Хүснэгт 10. Хөрөнгийн харьцаа**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Нийт хөрөнгийн эргэц	ROE	ROA
УСУГ ОНӨААТҮГ	0.21	0.01	0.01
Аймаг орон нутаг	0.63	-0.04	-0.02
УБ хот: Бусад ОНӨААТҮГ	0.60	-0.31	-0.10


УБ хот: Хувийн хэвшил	0.67	-0.04	-0.03
<b>Нийт</b>	<b>0.45</b>	<b>-0.05</b>	<b>-0.02</b>

Нийт хөрөнгийн эргэц гэдэг нь байгууллагын нийт хөрөнгийн үр ашгийг илэрхийлдэг бөгөөд зохистой хэмжээ байхгүй, өндөр байх тусмаа хөрөнгийн өгөөж сайн гэж үздэг. Энэ үзүүлэлтийн хувьд салбарын хэмжээнд 0.45 байгаа бол Улаанбаатар хотын хувийн хэвшлийн конторуудын хувьд хамгийн өндөр буюу 0.67 байна.

#### **4.6. Эх үүсвэр:**

Нийт эх үүсвэрийн 12%-ийг урт хугацаат өр төлбөр, 12%-ийг богино хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байгаа бөгөөд хуримтлагдсан алдагдал нь өмнөх оноос 4%-иар өсч 222 тэрбум төгрөг болсон байна. Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2022 оны өр төлбөр нь 389.6 тэрбум төгрөг байгаа бол 51%-ийг богино хугацаат өр төлбөр, 49%-ийг буюу 190.1 тэрбум төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

**График 15. Санхүүгий эх үүсвэрийн судалгаа /тэрбум төгрөгөөр/**



**Хүснэгт 11. Богино хугацаат өр төлбөрийн судалгаа /сая төгрөгөөр/**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2020 он	2021 он	2022 он	Өсөлт+ бууралт-	Өөрчлөлт хувь %
УСУГ ОНӨААТҮГ	7,300.1	1,426.4	3,354.1	1,927.62	135%
Аймаг орон нутаг	59,328.7	55,090.8	87,321.5	32,230.7	59%
УБ хот: Бусад ОНӨААТҮГ	15,581.5	23,416.6	21,997.2	-1,419.37	-6%
УБ хот: Хувийн хэвшил	76,022.1	82,271.6	86,877.5	4,605.86	6%
<b>Дүн</b>	<b>158,232.5</b>	<b>151,654.6</b>	<b>199,550.3</b>	<b>47,895.69</b>	<b>32%</b>

**Хүснэгт 12. Урт хугацаат өр төлбөрийн судалгаа /сая төгрөгөөр/**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2020 он	2021 он	2022 он	Өсөлт+ бууралт-	Өөрчлөлт хувь %
УСУГ ОНӨААТҮГ	204,411.5	549.6	578.3	28.7	5%
Аймаг орон нутаг	77,031.2	111,647.5	118,086.8	6,439.3	6%
УБ хот: Бусад ОНӨААТҮГ	45,302.8	45,260.6	54,330.3	9,069.7	20%
УБ хот: Хувийн хэвшил	13,007.1	14,252.3	17,071.0	2,818.7	20%
<b>Дүн</b>	<b>339,752.6</b>	<b>171,710.0</b>	<b>190,066.4</b>	<b>18,356.4</b>	<b>11%</b>

**Хүснэгт 13. 2022 оны өр төлбөрийн бүтэц /байршлаар/**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Богино хугацаат өр төлбөр		Урт хугацаат өр төлбөр		Нийт өр төлбөр	
	Хэмжээ, сая төгрөг	Эзлэх хувь, %	Хэмжээ, сая төгрөг	Эзлэх хувь, %	Хэмжээ, сая төгрөг	Эзлэх хувь, %
УСУГ ОНӨААТҮГ	3,354.1	<b>0.9%</b>	578.3	<b>0.1%</b>	<b>3,932.4</b>	<b>1.0%</b>
Аймаг орон нутаг	87,321.5	<b>22.4%</b>	118,086.8	<b>30.3%</b>	<b>205,408.3</b>	<b>52.7%</b>
УБ хот: Бусад ОНӨААТҮГ	21,997.2	<b>5.6%</b>	54,330.3	<b>13.9%</b>	<b>76,327.5</b>	<b>19.6%</b>
